

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

**1/9<sup>1</sup> дүгээр зүйл:**

**"9<sup>1</sup> дүгээр зүйл. Усны үндэсний зөвлөл**

9<sup>1</sup>.1. Усны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогын зөвлөмж өгөх, мэдээлэл харилцан солилцох үүрэг бүхий Усны үндэсний зөвлөл байна.

9<sup>1</sup>.2. Усны үндэсний зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд, зөвлөлийн нарийн бичгийн дарга нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

9<sup>1</sup>.3. Усны үндэсний зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлтэй зөвшилцэж Монгол Улсын Ерөнхий сайд батална."

**2/16<sup>1</sup> дүгээр зүйл:**

**"16<sup>1</sup> дүгээр зүйл. Усны асуудал эржэяасэн хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

16<sup>1</sup>.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд усны асуудал эржэяасэн хариуцсан төрийн захиргааны байгууллага ажиллана.

16<sup>1</sup>.2. Усны асуудал эржэяасэн хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг усны талаарх мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана.

16<sup>1</sup>.3. Усны асуудал эржэяасэн хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон сүм, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг усны талаарх мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

16<sup>1</sup>.4. Усны асуудал эржэяасэн хариуцсан төрийн захиргааны байгууллага нь усны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16<sup>1</sup>.4.1. Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, уг төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах;

16<sup>1</sup>.4.2.усны хайгуул, зураг төсөл, судалгааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хайгуул, судалгааны ажлын явцад хяналт тавих;

16<sup>1</sup>.4.3.усны ашиглах боломжит нөөцийн хэмжээг сав газрын хэмжээнд ашиглалтын зориулалт бүрээр тогтоон боловсруулж мөрдүүлэх, хяналт тавих;

16<sup>1</sup>.4.4.энэ хуулийн 4.9-д заасан ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг тогтоох санал боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих;

16<sup>1</sup>.4.5.улсын усны мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх, усны төлөв байдалтай хөябөгдсөн холбоотой мэдээллээр иргэн, хуулийн этгээдийг хангах;

16<sup>1</sup>.4.6.улсын усны тоо бүртгэл, статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулах, усны нөөц, ус ашиглалтын тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах;

16<sup>1</sup>.4.7.усны экологи-эдийн засгийн үнэлгээ, усны үнэ, тариф тогтоох чиглэлээр судалгаа хийх аргачлал, зааврыг боловсруулах, усны нөөцөд учруулсан хохирлыг тооцох;

16<sup>1</sup>.4.8.ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл, стандартыг дэвшилтэт технологи, шинжлэх ухааны ололтод тулгуурлан боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;

16<sup>1</sup>.4.9.энэ хуулийн 28.4-т заасны дагуу гаргасан ус ашиглах дүгнэлт, 28.6-д заасан ус ашиглах зөвшөөрөл, 28.11-д заасан гэрээнд хяналт тавих;

16<sup>1</sup>.4.10.голын голдирлыг өөрчлөх, урсацад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах;

16<sup>1</sup>.4.11.стратегийн томоохон орд гаэрүүдад газарт цооног өрөмдөх, ус ашиглах судалгаа хийхэд дүгнэлт гаргах;

16<sup>1</sup>.4.12.ган, цөлжилт, хуурайшилтын үед усны нөөц хомсдох, бохирдсон тохиолдолд тухайн сав газарт ус ашиглагчийн ашиглах усыг хуваарилах, хязгаарлах, ус, түүний орчныг нөхөн сэргээх зорилгоор ус ашиглахыг тодорхой хугацаагаар түр хориглох;

16<sup>1</sup>.4.13.бэлчээрийн усжуулалт, услалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд дүгнэлт гаргах;

16<sup>1</sup>.4.14.бэлчээрийг усжуулах зориулалтаар инженерийн хийцтэй худаг байгуулах, уст цэг тогтоох хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төлөвлөгөөг боловсруулах;

16<sup>1</sup>.4.15.хуульд заасан бусад бүрэн эрх."

2 дугаар зүйл.Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**"17.1.6.ус ашиглах зорилгоор цооног өрөмдөх, худаг гаргах, суваг хоолой татах тухай иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг үндэслэн энэ хуулийн 28.4-т заасны дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргах, улсын нөөцөд буртгэгдсэн рашааныг эмчилгээ-сувилаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах талаар дүгнэлт гаргах, мэдээллийн санд оруулж буртгэх;"**

**3 дугаар зүйл.**Усны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн "Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "Усны асуудал эрхяясан хариуцсан төрийн захиргааны байгууллага" гэж, 7 дугаар зүйлийн 7.4, 7.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.1.5 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийн "байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "усны асуудал эрхяясан хариуцсан төрийн захиргааны байгууллага" гэж, 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтын "байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад" гэснийг "усны асуудал эрхяясан хариуцсан төрийн захиргааны байгууллагад" гэж, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.15 дахь хэсгийн "байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын" гэснийг "усны асуудал эрхяясан хариуцсан төрийн захиргааны байгууллагын" гэж, 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийн "байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар" гэснийг "усны асуудал эрхяясан хариуцсан төрийн захиргааны байгууллагаар" гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын "нэгтгэн боловсруулж" гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.**Усны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.14, 10.1.15, 10.1.16, 10.1.17, 10.1.18, 10.1.19, 10.1.20, 10.1.21, 10.1.22, 10.1.23, 10.1.24, 10.1.26, 10.1.27 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

**Тогтоолын хавсралтад нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “4.Усны газар” гэж нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22” гэсэн дугаарыг “5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг